

# **“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**

## **ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2025 он 04 сар 28 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

### **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ БОЛОН ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 101210 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 117437 ширхэг энгийн хувьцааны 86,1% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 86,1% - ийг эзэмшигч хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Х.САРНАЙ

# **“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**

## **ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2025 он 04 сар 28 өдөр

Дугаар: 02

Улаанбаатар хот

### **Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай**

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дах заалт, 72-р зүйл, “Орхон Хөгжил” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 28–ны өдрийн ээлжит хуралд санал хураалтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Орхон Хөгжил” ХК–ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.  
Үүнд:
  - 1.1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.2 2025 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.3 “Орхон Хөгжил” Компаний цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах,  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.4 “Орхон Хөгжил” Компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн ногдол ашиг хувиарлахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Х.САРНАЙ

# **“ОРХОН ХӨГЖИЛ” ХК** **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН** **ТОГТООЛ**

2025 он 04 сарын 28 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

## **ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 63-р зүйлийн 63.5 дах заалт, 2025 оны 04 сарын 28-ний өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулж ирсэн тайланг баталсугай.
2. Компанийн 2025 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНЖАРГАЛ

# **“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**

## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 он 04 сар 28 өдөр

Дугаар: 22

Улаанбаатар хот

### **НООГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2025 оны 04-рсарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ноогдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай болон түүний үндэслэл тайлбарыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНЖАРГАЛ